**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 23 өдөр Дугаар А/93 Алтай хот

**Гамшгийн үеийн болон өвөлжилтийн бэлэн байдлыг хангах орон нутгийн бодлого, төлөвлөлтийн хүүхдэд ээлтэй байдлыг хангах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгийн үеийн болон өвөлжилтийн бэлэн байдлын орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны хүүхдэд ээлтэй байдлыг ханган Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн зөвлөмжийг хэрэгжүүлсүгэй.

2. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, салбар дундын зохицуулалтыг хийж ажиллахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc
0201000310

Аймгийн Засаг даргын 20..22..оны
..02..дугаар сарын..23..-ны өдрийн..А/93..дугаар
захирамжийн хавсралт

ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: -(Аймгийн Засаг даргын орлогч)

Багийн гишүүд: -(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

-(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

-(Онцгой байдлын газрын дарга)

-(Эрүүл мэндийн газрын дарга)

-(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

-(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

-(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

-(Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн төслийн орон нутгийн зохицуулагч М.Эрдэнэбилэг)

-(Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар)

Нарийн бичгийн дарга:-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

__oOo__